



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

**2019 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2019 он**

АГУУЛГА

Танилцуулга

Хуудас 2-3

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн биелэлт
- МУ-ыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт
- Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2018 онд хамтран ажиллах гэрээний биелэлт

Хуудас 4-4

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- Засгийн газрын тогтоолын биелэлт
- Засгийн Газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын биелэлт
- Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт
- Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын биелэлт
- Нийслэлийн Засаг даргаас 2019 оныг “Иргэдийн оролцоотой-хөгжлийн жил” болгон зарласан ажлын биелэлт
- Зөвлөмжийн биелэлт

Хуудас 4-4

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

- Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт
- Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа
- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа
- “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ

Хуудас 4-19

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- Үйл ажиллагааны ил тод байдал хүснэгтээр
- Хүний нөөцийн ил тод байдал хүснэгтээр

Хуудас 19-20

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

- Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажил
- Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар байгуулагдан, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр захирамжаар тус газрын бүтэц орон тоог 12 хүнтэй үүнээс дарга -1 байхаар баталж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2009 оны 01 дүгээр тушаалаар ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн -9 албан хаагчтайгаар анх үйл ажиллагаагаа эхэлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай А/323 дугаар захирамжаар тус газрын бүтэц орон тоог нэмэгдүүлэн шинэчилж 18, үүнээс дарга 1 байхаар баталж, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-12 /ТЗ/, мэдээллийн төвийн менежер-1, мэдээллийн технологи хаируцсан инженер-1, архив, бичиг хэргийн эрхлэгч-1 /ТҮ/ албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

2019 оны байдлаар тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай А/635 дугаар захирамжаар бүтэц орон тоог 18, үүнээс дарга, орлогч дарга, Захиргааны хэлтэс, Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс гэсэн нэгжтэй байхаар шинэчлэн баталж, 2019 оны Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай А/241 дугаар захирамжаар Бодлого, төлөвлөлтийн хэлтсийг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс болгон өөрчлөв. Мөн Нийслэлийн Засаг даргын 2019 оны Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай А/58 дугаар захирамжийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр мэдээлэл, сурталчилгааны төвийн ажилтан-4, нийт 23 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, нийслэл хотыг гадаад дотоодод сурталчлах, төрөөс аялал жуулчлалын чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх замаар Улаанбаатар хотыг Зүүн хойд Азийн соёл, бизнес болон дамжин өнгөрөх аялал жуулчлалын төв болох нөхцөлийг бүрдүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

АЛСЫН ХАРАА:

Аялал жуулчлалыг нийслэл хотын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэг бүхий салбар болгон хөгжүүлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Нийслэл Улаанбаатар хотыг гадаадын жуулчин хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

ХАМРАХ ХҮРЭЭ:


Нийслэлийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчид, аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагууд.

ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, шинээр бий болгох
2. Жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
3. Улаанбаатар хотын гадаад сурталчилгааг явуулж, зорих газрын менежментийн бодлого, маркетингийн стратегийг хэрэгжүүлэх

4. Жуулчдыг татах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын эдийн засаг, нийгмийн нөлөөллийг зохистой хэмжээнд байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах
5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх
6. Жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан төрөл бүрийн сургалт, судалгааны ажлууд зохион байгуулах
7. Нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 зорилт, 6 заалт, 6 арга хэмжээний хэрэгжилт 70%,
 - Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 5 зорилт, 27 арга хэмжээний биелэлт 85.8 %
 - МУ-ыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөөний 1 зорилт 7 арга хэмжээний **хэрэгжилт ...%**
 - Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4-ийн Аялал жуулчлалын төв болно зорилтын 10 заалтын хэрэгжилт 93%,
 - Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлийн 15 заалтын 22 арга хэмжээний **хэрэгжилт ... %**,
 - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2019 онд хамтран ажиллах гэрээний 2 зорилт, 12 арга хэмжээний хэрэгжилт 90%
 - “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг 2017 оны 06 сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр, өргөн барив.
- Нийт бодлогын баримт бичгийн **хэрэгжилт ... %**-тай байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- А. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2019 оны байдлаар:
- Засгийн газрын 5 тогтоолын 15 заалтын хэрэгжилт 97%
 - Засгийн Газрын 1 хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын 20 заалтын хэрэгжилт 100%,
 - Засгийн Газрын 1 албан даалгаврын 1 заалтын хэрэгжилт 100%,
 - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 3 заалтын 3 арга хэмжээний хэрэгжилт 90%
 - Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт 100%
- Нийслэлийн Засаг даргын 2 албан даалгаврын 7 заалтын хэрэгжилт ... %**
- 2019 оны жилийн эцсийн байдлаар тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 97%-тай байна.
- Б/. Нийслэлийн Засаг даргын 2019 оныг “Иргэдийн оролцоотой-хөгжлийн жил” болгон зарлах тухай захирамжийн дагуу тус газар 3 зорилт 12 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан баталж, 2019 оны жилийн эцсийн байдлаар 97%-тай хэрэгжүүлэн ажиллав.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН


А/. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:

1. Аялал жуулчлалын байгууллага болон жуулчдад үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны


үйл ажиллагаа эрхлэх журам"-ын дагуу аж ахуйн нэгж байгууллагаас зочид буудал, дэн буудал, амралтын газрын зөвшөөрөл хүссэн хүсэлтийн дагуу ажлын хэсэг стандартын үзлэг шалгалтыг санал хүсэлт ирснээс хойш 7 хоногт багтаан шийдвэрлэхийг гол зорилтоо болгон ажиллаж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар тус газар 785 хүсэлт ирснээс стандартын шаардлага хангасан 470 байгууллагад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосны 243 зочид буудал, 196 дэн буудал, 31 амралтын газар, жуулчны бааз байна. Стандартын шаардлага хангаагүй 315 байгууллагад заавар зөвлөгөө өгч ажиллав.

Стандартын шаардлага ханган үйл ажиллагаа явуулж зочид буудал, дэн буудлын тоон үзүүлэлт, сүүлийн 5 жилээр гарфикаар үзүүлбэл:



2015 оны 10 дугаар сараас Нийслэлийн хотын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-ын 7.2.1, 7.2.2-ын заалтын дагуу зочид буудал, амралтын газрын үйлчилгээний төлбөрөөс 1 хувийн албан татвар авдаг болсон. Олон улсад уг татварын орлогыг аялал жуулчлал, хотын дэд бүтцийг хөгжүүлэхэд зарцуулдаг байна.

Нийслэлийн хотын албан татварт аялал жуулчлалын салбарын орлогыг сүүлийн 4 жилээр үзүүлбэл:



2. Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарын нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах ажлын хүрээнд:

“Аялал жуулчлал ба хөдөлмөр эрхлэлт-2019” хөдөлмөрийн яармаг зохион байгуулав.

“Аялал жуулчлал ба хөдөлмөр эрхлэлт-2019” хөдөлмөрийн яармагийг 03 дугаар сарын 29, 30, 31-ний өдрүүдэд “ITM олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн”-гийн үеэр 10:00-17:00 цагийн хооронд “Мишээл экспо” төвд амжилттай зохион байгууллаа. Хөдөлмөрийн яармагийн мэдээллийг өөрсдийн судалгаанд үндэслэн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 80 гаруй тур оператор, тур агент, жуулчны баазуудад хүргэлээ. Мөн “Монголын Зочид буудлуудын холбоо”-той хамтран зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг 400 орчим байгууллагад цахим сүлжээгээр мэдээллийг түгээлээ. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газарт ирүүлсэн 400, аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагууд болох зочид буудал, рестарон, жуулчны баазуудын 200, нийт 600 гаруй нээлттэй ажлын байрыг зарласан. Хөдөлмөрийн яармагт давхардсан тоогоор 1000 гаруй хүн оролцож, яармагийн үеэр 210 иргэнийг нийт 60 ажил олгогч компанид зуучилж түр болон байнгын ажлын байраар хангалаа.



“Улаанбаатар” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулав.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран “Улаанбаатар” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг 2019 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд “Хоггүй байгалийн төлөө” уриан доор “Мишээл экспо” төвд 5 дахь жилдээ зохион байгууллаа. Үзэсгэлэнгийн түнш улсаар БНСУ, түнш аймгаар Дорнод аймаг оролцов. Үзэсгэлэнд 86 байгууллага оролцож дотоод, гадаадын 6000 гаруй иргэд, жуулчдад аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ, чиглэл, үнэ, харилцаа холбоо, аяллын даатгал болон шинэ үйлчилгээний талаар цогц мэдээ, мэдээллийг өгч ажиллалаа. Мөн БНСУ-аас эрүүл мэндийн аялал жуулчлалын компаниуд эмчийн үзлэг, оношилгоог үнэ төлбөргүй хийж, зөвлөгөө өгөв.



“Хотын аялал”-ыг зохион байгуулав.

Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ой болон “Дэлхийн аялал жуулчлалын өдөр”-ийг тохиолдуулан Монголын Зочид буудлуудын холбоо, Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэг, Улаанбаатар музейтэй хамтран 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр

“Хотын аялал”-ыг зохион байгуулсан. Аялалд 6 их сургуулийн аялал жуулчлалын чиглэлээр суралцаж буй 1-р курсын 40 оюутан хамрагдаж Улаанбаатар хотын түүх, соёлын дурсгалт газруудтай танилцсан. Аяллын үеэр оюутнуудад “Дэлхийн Аялал жуулчлалын өдөр”-ийн “Аялал жуулчлал ба ажлын байр” уриатай холбогдуулан сургуулиа төгсөөд зочлох үйлчилгээний байгууллагад ажиллах нөхцөл боломжийн талаар Холидэй Инн зочид буудлын удирдлагууд яриа хийв.



Явган алхагчдын фестиваль зохион байгуулав.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, БНСУ-ын Жэжү хотын Аялал жуулчлалын газар, “Жэжү Олле” нийгэмлэгтэй хамтран Улаанбаатар хот орчимд Олле стандартын явган аяллын чиглэл /маршрут/ тогтоон тэмдэгжүүлэх ажлыг 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа билээ. Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Жэжү Олле” нийгэмлэгтэй хамтран 2019 оны 07-р сарын 17-ны өдөр Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт тохижуулсан Монгол Оллэ явган аяллын маршрутаар 2 улсын явган алхагчдын фестивалийг зохион байгууллаа. Солонгос улсаас 70 алхагч, Монгол улсаас Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ, Хайрхан аялагч клуб, Мазаалай аялагч клуб, UB Хайкинг клуб, Эрүүл Монгол Хайкинг клубын

төлөөлөгчид нийт 100 гаруй хүн оролцож 11 км-ийн хамтарсан алхалтыг хийсэн бөгөөд Солонгосын Agirang TV-ээс нэвтрүүлэг бэлтгэсэн. Энэ үеэр Тэрэлжийн гол орчмын хогийг цэвэрлэж, орон нутгийн иргэдийн хийсэн гар урлалын бүтээгдэхүүний худалдаа, цагаан идээний худалдаа зохион байгуулагдлаа.



Агро аяллыг зохион байгуулав.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Улаанбаатар хотын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран хувиараа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зорилготойгоор 2019 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Тарвагатайн аманд байрлах Улаанбаатар агропарктай танилцах Агро аяллыг зохион байгуулав. Аяллаар Улаанбаатар агропаркын нарийн ногоо тариалдаг 50 хүлэмж, 100 га газар бүхий ил задгай талбайн ногоо хураалттай танилцаж, агропаркийн агрономч Ж.Сүрэнжав хэрхэн нарийн ногоо болон төмс хүнсний ногоо тарих, хураах талаар зөвлөгөө өгч, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд шинэлэг санаа санаачлага харилцан туршлага солилцон өөрсдийн биеэр ногоо хураалтад оролцов.



3. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгэм, соёлын нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд:

“Улаанбаатарын өвлийн наадам-2019” арга хэмжээг зохион байгуулав.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/67 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатарын өвлийн наадам-2019” арга хэмжээг 2 дугаар сарын 16, 17-ны өдөр “Скай резорт” цанын баазад зохион байгуулав. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улирлын уламжлалт болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирсэн жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилготой тус арга хэмжээнд ОХУ-ын Буриад улсаас 10, Тува улсаас 10, БНХАУ-ын ӨМӨЗО-ноос 20, нийт 40 тамирчин хүрэлцэн ирж, мөсөн сурын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцлоо. Мөн ОХУ-ын Эрхүү мужийн “АИСТ ТВ” болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Монгол Одон ТВ”-ийн хэвлэл мэдээллийн 4 төлөөлөгч ирж сурвалжлав. “Улаанбаатарын өвлийн наадам-2019” арга хэмжээнд нийт 12 аймгийн 600 гаруй тамирчин, Улаанбаатар хотын 300 гаруй тамирчин нийт 900 гаруй тамирчин оролцож, наадмыг гадаад, дотоодын 9,000 гаруй хүн үзэжсонирхсон байна.



“Бүргэдийн баяр-2019” арга хэмжээг зохион байгуулав.

Жуулчны улирлын хугацааг уртасгах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, төв Азийн нүүдэлчин ард түмний соёл, зан заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, нийслэлийн иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/86 дугаар захирамжийн дагуу “Бүргэдийн баяр-2019” арга хэмжээг 3 дугаар сарын 03, 04-ний өдөр Хан-Уул дүүргийн 8-р хороо, Богд хан уулын Жаргалантын аманд байрлах Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа. Арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Бүргэдчид холбоо ТББ, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо ТББ-тай хамтран зохион байгуулав. Бүргэдийн баярт АНУ,

Кувейт, Турк, Казакстан зэрэг улсын Элчин сайдын яамын төлөөллүүд, гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 5,000 орчим хүн үзэж сонирхсон байна. Үүнээс гадаадын 200 гаруй жуулчин байсан.



“Талын салхи” олон улсын мото наадам зохион байгуулав.

“Талын салхи” олон улсын мото наадмыг нийслэлийн Засаг даргын 2019 оны А/501 дүгээр захирамжаар “Монголын Чопперчин ахан дүүс” ТББ-тай хамтран 6 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Улаанбаатар хот-“Цонжин Болдог” Чингис хааны хөшөөт цогцолбор чиглэлд зохион байгууллаа. Монгол, БНХАУ, ОХУ-ын Цайны замын хүрээнд ОХУ-аас 15 клубын 120, БНХАУ-аас 5 клубын 40, Энэтхэг, Япон, Европын холбооны улсаас 20 гаруй, дотоодын 20 клубын 600 гаруй мото сонирхогч, нийт 800 гаруй тамирчин оролцлоо. Жанжин Д.Сүхбаатарын талбайн нээлт болон “Цонжин Болдог” Чингис хааны хөшөөт цогцолборт болсон урлаг, соёлын арга хэмжээг нийт 5000 гаруй иргэд, жуулчин үзэж сонирхсон байна.




“Дээлтэй Монгол наадам” арга хэмжээг зохион байгуулав.

Нийслэлийн Засаг даргын А/665 дугаар захирамжийн дагуу “Дээлтэй Монгол наадам” арга хэмжээг жанжин Д.Сүхбаатарын талбайд 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр үндэсний дээл хувцасны загварын үзүүлбэр, дүүрэг, аж

ахуй нэгж байгууллага иргэдийн парад, үндэсний уламжлалт зан үйл, ёс заншил, дээл хувцас, хэрэглэл, тоглоом наадгай, гар урлал зэргийг үзүүлсэн гэр хотхон, мөн үндэсний дээл хувцас, хэрэглэлийн үзэсгэлэн худалдааг явуулав. Арга хэмжээний парадад оролцогч иргэд, аж ахуй нэгж, дүүргүүдэд үндэсний дээл хувцасыг иж бүрнээр нь өмсөх шаардлага тавьсан бөгөөд нийт 6 дүүрэг, 8 аж ахуй нэгжийн 1500 гаруй хүн жагсаж, тайз дэлгэцийн үндэсний хувцасны загварын үзүүлбэрт 55 хүүхэд, 60 гаруй загвар өмсөгчид болон 30 гаруй хүн урлаг соёлын тоглолт хийж нийт 7000 гаруй хүн оролцож үзэж сонирхсоноос 1000 гаруй нь гадаадын жуулчид байлаа. Энэ жил ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улсын Эдегей хамтлагийн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчид Монгол туургатны Тува угсаатны хувцасны 3 коллекц үзүүлбэр, БНХАУ-ын ӨМӨЗО-ын Алша аймгийн Эзнээ хошууны Торгууд хувцас заслын компанийн 14 төлөөлөгчид Торгууд угсаатны хувцасны загварын үзүүлбэр, “Монгол үндэстний гоо бүсгүй” шалгаруулах тэмцээнд оролцогч Монгол туургатан улсуудаас бүрдсэн 16 мисс загварын үзүүлбэр үзүүлж Монгол туургатан улсуудыг хамруулсан нь энэ удаагийн наадам онцлог байлаа. “Дээлтэй Монгол наадам”-ыг нээж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан үг хэлэв.



Үндэсний хувцасны үзүүлбэр





Үндэсний хувцастай иргэдийн парад





Урлагын тоглолт





Арга хэмжээний үеэр үндэсний дээл хувцас, тоглоом наадгай, эд зүйлсийг сурталчилж ажиллав.





Оролцогчдыг шалгаруулав.



“Богдхан уулын трейл 2019” олон улсын гүйлтийн тэмцээн зохион байгуулав.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн А/746 дугаар захирамжаар “Богдхан уулын трейл 2019” олон улсын гүйлтийн тэмцээнийг 7 дугаар сарын 28-ны өдөр Богдхан ууланд зохион байгууллаа. Уг тэмцээн нь “Олон улсын трейл раннинг холбоо”, “Азийн трейл мастер холбоо”-ний гишүүн бөгөөд 64 км-ийн уралдаанд амжилттай оролцсон тамирчдад ITRA 3 оноо өгөх уралдаан “Ultra trail Mont Blanc”-д оролцох боломжийг олгож, тамирчдыг Монгол улсад татах нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа онцлог юм. Энэ жилийн тэмцээнд Монгол, Япон, Сингапур, БНСУ, АНУ, ХБНГУ, Канад, Испани зэрэг 9 улсын 3 насны ангилалд 10,21,64 км-ийн зайд 163 орны тамирчид өрсөлдөж 500 гаруй хүн үзэж сонирхлоо.



“Тал нутгийн Монгол 2019” олон улсын марафон гүйлтийн тэмцээн зохион байгуулав.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн А/746 дугаар захирамжаар “Тал нутгийн Монгол 2019” ОУ-ын марафон гүйлтийн тэмцээнийг 9 дүгээр сарын 08-ны өдөр Хүй долоон худагт зохион байгуулав. Өсвөр үе, насанд хүрэгчид, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг 4 насны ангилалд 3км, 5км, 10км, 21км-ийн зайд зохион байгуулсан. Монгол, Япон, Сингапур, БНСУ, АНУ, ХБНГУ, ОХУ зэрэг 7 улсын 1612 хүн оролцсоноос гадаадын 186 тамирчид байж, нийт 3000 гаруй хүн үзэж сонирхлоо.





“Солонгосын долоо хоног” арга хэмжээг зохион байгуулав.

Нийслэл Улаанбаатар хотыг Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болгох зорилтын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр Нийслэлийн Засаг даргын А/818 дугаар захирамжийн дагуу Монгол дахь Солонгос иргэдийн нийгэмлэгтэй хамтран 2019 оны 8 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд Солонгос улсын соёл, хөгжим урлаг, үндэсний хувцас, хоол зэргийг таниулсан “Солонгосын долоо хоног” арга хэмжээг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа. Энэ удаагийн арга хэмжээ нь К-Рор, М-Рор хөгжмийн урсгалын тэмцээн, К-Рор бүжгийн тэмцээн, Солонгосын үндэсний хөгжмийн үзүүлбэр, Солонгос үндэсний хувцасны шоу, Солонгосын үндэсний бийрэн бичлэг, Солонгос хоолны танилцуулга, амталгаа, “Face of Mongolia” моделин тэмцээн, Гоо даамны тэмцээн, Монгол үндэсний урлагийн үзүүлбэр, Азын сугалаа зэрэг сонирхолтой үйл ажиллагаанууд явагдаж, үзэгчдийг оролцуулсан 6 өдрийн хөтөлбөр байлаа. Арга хэмжээнд нийт 100 гаруй хүн зохион байгуулалтад оролцож, нийт зохиогдсон үйл ажиллагаа, тэмцээнүүдэд 1000 орчим хүн хамрагдаж нийт 6 өдрийн турш 8000 гаруй хүн үзэж сонирхлоо.



“Япон соёлын наадам” арга хэмжээг зохион байгуулав.

“Япон соёлын наадам” арга хэмжээг 9 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд болон Дуурийн театрт “Летс травел ХХК”-тай хамтран Япон соёл, Япон амт, Япон чанартай танилцах “Японы нэг өдөр” уриан дор зохион байгууллаа. Япон улсын Softbank group, SB Players, Tabirism компаниуд хамтран зохион байгуулагчаар оролцож Япон улсаас 6 компани, Монгол улсаас Японы гоо сайхан, ресторан, сургалтын төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 нийт 36 аж ахуй нэгж оролцож бараа бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан арга хэмжээг нийт 2 өдрийн турш 19000 хүн үзэж сонирхсон.



“Бидний бүтээл сансарт” цуврал арга хэмжээг зохион байгуулав.

Улаанбаатар хотын 380 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын А/1000 дугаар захирамжийн дагуу “Монголын Сансрын судалгаа, хөгжүүлэлтийн төв”-тэй хамтран хүүхэд залуучуудын бүтээлч, шинжлэх ухаанч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор “Бидний бүтээл сансарт” цуврал арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд жанжин Д.Сүхбаатарын талбайд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр задгай сансарт 38000 метрийн өндөрт эрдэм шинжилгээ, судалгаа шинжилгээний тусгай зориулалтын 3 ширхэг сансрын бөмбөлгийг хөөргөлөө. Ингэснээр Монгол Улс нь нийслэл хотынхоо төв талбайгаасаа задгай сансарт бөмбөг хөөргөсөн дэлхийн анхны улс болон тэмдэглэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 6-9-р ангийн сурагчид буюу 12-15 насны сурагчдын дунд бүтээлийн уралдаан зарлаж, ирсэн 243 хүүхдийн 81 бүтээлээс шилдэг 20 бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж олон нийтэд таниулан, шилдэг 3 болох Монгол Улсын Багшийн их сургуулийн Лицей сургууль, Өсвөрийн зохион бүтээгчдийн дунд сургууль, Баянзүрх дүүргийн Глобал олон улсын сургуулийн сурагчдын бүтээлүүдийг сансрын бөмбөгт байршуулан хөөргөлөө. Иргэдэд өөрийн нэр бүхий нэрийн хуудсыг сансрын бөмбөлгөнд байршуулан сансарт хөөргөх ажлыг өрнүүлэн marsa.mn

цахим хуудсан дээр 5745 иргэн бүртгүүлснээс санамсаргүй түүврийн аргаар 380 иргэний нэрсийг тодруулан хөөргөсөн. Мөн Улаанбаатар хотын агаарын чанарыг тоон үзүүлэлтээр хэмжих тоног төхөөрөмжийг байршуулан хөөргөсөн. Сансрын 3 бөмбөлөг 33,300, 33200, 33100 метрийн өндөрт буюу агаар мандалын Стратосфера давхаргад хүрээд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутагт буусан. Арга хэмжээнд нийт 300 гаруй хүн оролцож 1000 гаруй хүн үзэж сонирхлоо.





4. Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах чиглэлээр:

- Нийслэлийн Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний ажлын даалгаврын төслийг боловсруулсан ба санхүүжилтгүйн улмаас хийгдэх боломжгүй болсон.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Хөрөнгө оруулалт, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор “Улаанбаатар тусгай бүс” байгуулна” гэсэн зорилтын хүрээнд Улаанбаатар хотод аялал жуулчлалын тусгай бүсийг төрөлжүүлэн хөгжүүлэх, олон улсын тусгай бүсийн

үйлчилгээний төрөл, шаардлага, чиглэл болон аялал жуулчлалын салбарт хийгдсэн зах зээлийн судалгаануудыг нэгтгэж, 2019 оны 04 дүгээр сарын 03-нд “Нийслэлийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлаар холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т хүргүүлэн, тус ажлын хэсгийн ахлагч Р.Дагватай уулзаж, санал солилцсон. Мөн 2019 оны 05 дугаар сарын 30-нд НИТХ-д чөлөөт бүсэд аялал жуулчлалын чиглэлээр хийгдэх ажлуудын саналыг танилцуулга хэлбэрээр хүргүүллээ.

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Ерөнхий сайдын 2019 оны 52 дугаар захирамжийн дагуу "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /2020-2045/", уг бодлогыг "2020-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж байгаатай холбогдуулан нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх саналууд болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн НЗДТГ-т хүргүүллээ.

5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, УБ хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах, үйл ажиллагаанд мэргэжлийн холбоодын зөвлөмж, санал, дүгнэлтийг тусгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

- “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг холбогдох байгууллагуудаас санал авч, иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллөөр хэлэлцүүлэн саналыг тусгав.

- 2018 онд БОАЖЯ-ны захиалгаар Үндэсний Аялал жуулчлалын байгууллага ТББ Монгол улсын албан болон бизнес аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, судалгааны тайланг БОАЖЯ, НАЖГ-т ирүүлсэн. Ирүүлсэн судалгааны дагуу “Албан болон бизнесийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр, Үндэсний Аялал жуулчлалын байгууллагатай 2018 оны 08-р сарын 31-ний өдөр гэрээ байгуулсан. Тус ажилд шаардагдах 9.057.950 төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Хөрөнгө гаргах тухай” А/906 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. “Албан болон бизнесийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төсөл боловсруулж 2019 оны 01/509 тоот албан бичгээр байгууллагуудаас санал авахаар хүргүүлэв.

6. Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулах, энэ чиглэлээр маркетингийн стратеги, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Улаанбаатар хотыг гадаадад сурталчилж, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож, аялал жуулчлалын маркетинг сурталчилгаанд интернэт, нийгмийн сүлжээг ашиглан Улаанбаатар хотыг гадаадад сурталчлав. Үүнд:

“Ай-Ти-Би Берлин 2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов.

ХБНГУ-ын Берлин хотод 2019 оны 03 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ай-Ти-Би Берлин 2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/120 тоот захирамжаар нийслэлийн төлөөлөгчид, уран бүтээлчдийн нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй баг болон БОАЖЯ, МИАТ ХК, Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам, аялал жуулчлалын тур оператор компаниуд оролцож Улаанбаатар хотыг сурталчлан оролцсон. Тус газраас А4 хэмжээтэй герман хэл дээрх “Улаанбаатар-Таны Монголд хүрэх үүд хаалга” сэтгүүлийг бэлтгэн 1500 ширхгийг үзэсгэлэнгийн үеэр тарааж ажиллав. Тус үзэсгэлэнд 181 орны 10,000 гаруй аялал

жуулчлалын бизнес эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд оролцсон ба 170.000 хүн ирж сонирхсон.



“Байкалтур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов.

ОХУ-ын Эрхүү хотод хотод 3 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Байкалтур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нийслэлийн Засаг даргын 2019 оны А/216 тоот захирамжийн дагуу оролцов. Үзэсгэлэнд БОАЖЯ, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Улаанбаатар чуулга, Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, УБТЗ ХНН, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Улаанбаатар телевиз болон аялал жуулчлалын 10 компанийн төлөөлөл нийт 40 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцож Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээллийг өгч, 80 нүүр бүхий орос хэл дээрх Улаанбаатар сэтгүүл, газрын зураг, хөтөч номыг түгээж ажилласан. Үзэсгэлэнд ОХУ, БНХАУ, БНСУ-ын нийт 100 гаруй аялал жуулчлалын байгууллагууд оролцож 10.000 гаруй хүн сонирхсон байна. Монгол Улсын төлөөлөл үзэсгэлэнд оролцогчдод олгодог тэргүүн шагнал болох “Золотая награда” цомыг өргөмжлөлийн хамт хүртэв.



Орос, Монгол, Хятад гурван улсын Аялал жуулчлалын сайд нарын дөрөв дэх удаагийн уулзалт, гурван улсын “Цайны зам” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд орлцов.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос, Улаан цав хотуудад 6-р сарын 19-нөөс 27-ны өдрүүдэд “Улаанбаатар хотын соёл, аялал жуулчлалыг сурталчлах өдөрлөг” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд албаны болон аялал жуулчлалын бизнес эрхлэгч, үндэсний үйлдвэрлэгч, нийслэлийн Улаанбаатар чуулгын уран бүтээлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудаас бүрдсэн 55 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Улаанбаатар хот, Монгол Улсыг сурталчлан ажиллаа. Мөн энэ үеэр ӨМӨЗО-ны Жинин хотод зохион байгуулагдсан Орос, Монгол, Хятад гурван улсын Аялал жуулчлалын сайд нарын дөрөв дэх удаагийн уулзалт, гурван улсын “Цайны зам” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгуудын байгаль орчин, аялал жуулчлалын газруудын төлөөлөл, үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцож бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцууллаа. Тус үзэсгэлэнд 3 улсын нийт 120 гаруй аж ахуй нэгж, байгууллагууд оролцсон.



Үзэсгэлэнд үндэсний үйлдвэрлэгч “Түмэн хишигтэн” ХХК, “Талын эзэн” ХХК /НААД брэнд/, “Маяара трейд” ХХК болон аялал жуулчлалын салбарын “World class” ХХК, “Манжуурын аялал” ХХК, “Юнайтед экспресс” ХХК, тусгай сонирхлын аялал жуулчлалын “Morning glory” ХХК, Хэнтий аймгийн “Чингисийн тоонот” ХХК, Өмнөговь аймгийн “Гайхамшигт говь” аялал жуулчлалын холбоо, “Өнөрговь” ХХК, Сүхбаатар аймгийн “Агтана хүрээ” ХХК, Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын холбооны төлөөлөл оролцож бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж Улаанбаатар хот, Монгол Улсыг сурталчлан хамтран ажиллав.

ФАМ тур аялал зохион байгууллаа.

Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны байгууллага” болох ФЕАЛАК-ийн гишүүн орнуудын 10 гаруй сэтгүүлчдийг 2019 оны 07-р сарын 08-14-ны өдрүүдэд Улаанбаатар хотод хүлээн авч, ФАМ тур аялал зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагааг Гадаад хэргийн яамны гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газар, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Соёл урлагийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Аялал жуулчлалын холбоо хамтран зохион байгуулсан бөгөөд Улаанбаатар хот, хот орчмын үзэсгэлэнт байгаль, Үндэсний их баяр наадмын үйл ажиллагаатай танилцуулав.

БНСУ-ын SEONGNAM хотод зохион байгуулагдсан “SEONGNAM INTERNATIONAL MEDICAL TOURISM” арга хэмжээнд оролцов.

БНСУ-ын Seongnam хотын захиргаа тус хотын Анагаах ухааны нийгэмлэг, Эрүүл мэндийн аялал жуулчлалын зөвлөл хамтран эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээ, техник төнөг төхөөрөмж үйлдвэрлэгч компаниудын үйл ажиллагааг сурталчлах, түншлэл тогтоох зорилгоор 2019 оны 9 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд Seongnam хотын захиргааны байрны City Hall танхимд “Seongnam international medical tourism” арга хэмжээг зохион

байгууллаа. 2 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа энэхүү арга хэмжээнд Улаанбаатар хотоос эрүүл мэндийн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг EMJJ, Luujin holding, Exodus, Airman, Бирга тур зэрэг компаниуд болон Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төлөөллүүд оролцов. Арга хэмжээний үеэр “Seongnam international medical tourism” олон улсын чуулган болж, чуулганд Орос, Хятад, Монгол, Вьетнам, Тайланд, Тайван, Индонез, Казакстан зэрэг 13 орны төрийн болон хувийн хэвшлийн 500 гаруй зочид төлөөлөгч оролцов.



Мөн арга хэмжээний үеэр эрүүл мэндийн байгууллага, төнөг төхөөрөмж үйлдвэрлэгч компаниудын үзэсгэлэн зохион байгуулагдаж 68 компани 120 стэндэд үйл ажиллагаагаа танилцуулав.



Мөн эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээ, техник төнөг төхөөрөмж үйлдвэрлэгч компаниудын үйл ажиллагааг сурталчлах фам тур арга хэмжээ зохион байгуулагдаж Tplus шүдний эмнэлэг, Nubebe ардын уламжлалын эмнэлэг, Dedipium гоо сайхны эмнэлэгийн үйл ажиллагаатай танилцав. Бизнесийн зөвлөгөөн болж 150 гаруй байгууллага бизнесийн уулзалт хийж түншлэлээ тогтоов.



Тяньжинь-Улаанбаатар хотуудын соёл, аялал жуулчлалын өдрүүд арга хэмжээнд оролцов.

Найрамдалт харилцаат Тяньжинь-Улаанбаатар хотуудын соёл, аялал жуулчлалын өдрүүд арга хэмжээ 2019.10.26-11.01-ний өдрүүдэд БНХАУ-ын Тяньжинь хотод зохион байгуулагдсан. Энэхүү арга хэмжээг Монгол Улс Бүгд Найрамдах Хятад Ард Улстай дипломат харилцаа тогтоосны 70 жил, Улаанбаатар хот-Тяньжинь хоттой найрамдалт харилцаа тогтоосны 27 жилийн ойн хүрээнд Монгол дахь Хятадын соёлын газар, Тяньжинь хотын соёл, аялал жуулчлалын газар болон Тяньжинь хотын захиргааны гадаад хэргийн албанаас зохион байгуулсан ба Монголын талаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Монголын аялал жуулчлалын холбоо, Актив адвенчер тур ХХК, Бирга тур ХХК болон язгуур урлагийн Алтай хамтлаг, Улсын филармонийн төлөөллүүд зэрэг 17 хүн оролцож Монголын соёл, аялал жуулчлалыг сурталчлан оролцлоо.



БНСУ-ын Бусан хотод зохион байгуулагдсан “Азийн явган аяллын бага хурал 2019”, явган аяллын фестивалд оролцов.

БНСУ-ын Бусан хотод 2019 оны 10 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Азийн явган аяллын бага хурал 2019”, явган аяллын фестивалд тус газраас төлөөлөл оролцож Улаанбаатар хот болон Монгол Оллэ явган аяллын замыг сурталчлан ажиллав. Бага хуралд нийт 13 орны 35 байгууллагын төлөөлөгчид ороцож явган аяллын замын онцлогийг танилцуулан Бусан хотын 3 төрлийн явган аяллын замаар алхаж явган аяллын фестивалд оролцов. Фестивалд Солонгос улсын нийт 45 клубын 3000 гаруй алхагч нар ирж оролцсон.



БНСУ-ын Жэжү аралд зохион байгуулагдсан явган аяллын фестивалд оролцов.

Жэжү оллэ нийгэмлэгийн урилгаар 2019 оны 10 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Жэжү арлын Жэжү оллэгийн 3 аяллын замаар алхаж тохижилтын ажил, мэдээллийн төвүүтдэй танилцаж туршлага солилцов. Жежү арлыг тойрсон 26 курс, 425 км явган аяллын тэмдэгжүүлсэн зам байдаг ба зам дагуух тэмдэг, тэмдэглэгээ нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй материалуудаар хийгддэг юм байна. Жэжү Оллэ аяллын замын эхлэл цэг бүрт

мэдээллийн төв байдаг ба алхаж ирээд аяллын замын тамгыг тэмдэглэлийн дэвтэр дээр дарж баталгаажуулдаг.



БНСУ-ын Жежу хотын “Жежу Олле” нийгэмлэгээс зохион байгуулсан явган алхалтын фестивальд оролцов.

БНСУ-ын Жежу хотод “Жежу Олле” нийгэмлэгээс 2019 оны 10 дугаар сарын 29-05-ны өдрүүдэд 10 дахь жилдээ зохион байгуулсан “Жежу олле” явган аяллын фестивальд Нийслэлийн Аялал жуулчлалын газар, БОАЖЯ-ны төлөөлөл, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Хашмаргад, Монголын Аялал жуулчлалын хөгжлийн төвийн менежер Д.Бадрах, Нийслэлийн Налайх дүүргийн 6-р хорооны Засаг дарга Ц.Болд, Баянзүрх дүүргийн 11-р хорооны Засаг дарга Х.Эрдэнэсайхан болон 6,11-р хороодын иргэдийн төлөөлөл оролцлоо. Фестивальд 6 орны 3000 хүн хамрагдаж алхлаа.



Олле гэдэг нь Жежүгийн эртний хэллэгээр “гудамж талбайгаас гэрийн хашаа хүртэлх нарийхан зам” гэсэн утгатай үг бөгөөд БНСУ-д 2006 оноос хойш Жежу арлыг тойрсон 26 курс, 425 км явган аяллын чиглэлийг тэмдэгжүүлсэн байдаг юм. Олле явган аяллын чиглэл нь Солонгос улсад хурдан хугацаанд хөгжиж, олон хүний алхах дуртай зам болсон бөгөөд зам дагуух тэмдэг, тэмдэглэгээ нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй материалуудаар хийгддэг. Олле стандартын дагуу тэмдэглэгээ хийхдээ зам дагуу шар, цэнхэр өнгийн тууз бүхий нарийхан шон хатгаж, тэмдэглэгээ тавих бөгөөд зөвхөн эхлэл, төгсгөл цэг дээр мэдээллийн самбарууд байрлана. Үүнээс гадна Оллэгийн үндсэн бэлгэ тэмдэг болох морь хэлбэртэй кансейг чиглэл заасан тэмдэг болгон ашигладаг. Явган аяллын замаар алхаж байгаа хүн орон нутгийн иргэдийн аж амьдралтай танилцаж, иргэдийн аж амьдралд бодит хувь нэмэр оруулах шаардлагатай гэж үздэг нь Оллэ стандартын гол онцлог юм.

Гадаад оронд зохион байгуулагддаг үзэсгэлэн, олон улсын соёл, аялал жуулчлалын арга хэмжээнд оролцож Улаанбаатар хотын сурталчилгаа хийснээр Монгол Улсын аялал жуулчлалын зах зээлд эзлэх байр суурийг баталгаажуулах, өрсөлдөх чадвар, жуулчдын тоог нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм. Үүний үр дүнд 2019 оны эхний 11 сарын байдлаар Монгол улсад **529.370 жуулчин ирсэн ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 11.01%-иар, салбарын орлого 569.542.966 ам доллар буюу 29.6%-иар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.**

2019 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН ЖУУЛЧДЫН МЭДЭЭГ ӨНГӨРСӨН ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСАН МЭДЭЭ				
Монгол улсад ирсэн нийт гадаадын иргэд	2018 оны 11 сар	2019 оны 11 сар	Өмнөх оны мөн үе ялгаа /тоо/	Өмнөх оны мөн үе ялгаа /хувь/
Нийт: Зорчигч	565,843	605,824	39,981	7.1
Үүнээс: Жуулчин	501,486	549,756	48,270	9.6
1 АЗИ НОМХОН ДАЛАЙ	283,313	312,522	29,209	10.3
2 ЕВРОП	191,997	208,890	16,893	8.8
3 АМЕРИК	23,056	24,368	1,312	5.7
4 АФРИК	887	934	47	5.3
5 ОЙРХИ ДОРНОД	2,233	3,042	809	36.2
Жуулчид голлох зах зээлийг орноор				
1 Хятад	151,832	157,828	5,996	3.9
2 Орос	120,369	132,799	12,430	10.3
3 Солонгос /Өмнөд/	81,774	98,106	16,332	20
4 Япон	20,115	23,466	3,351	16.7
5 Америк	17,390	18,371	981	5.6
6 Казакстан	15,475	15,521	46	0.3
7 Герман	10,628	12,232	1,604	15.1
8 Франц	9,614	10,465	851	8.9
9 Австрали	7,256	6,782	(474)	-6.5
10 Тайван	5,156	5,852	696	13.5
11 Их Британи	5,805	5,826	21	0.4
12 Хятад, Хонконг	3,017	4,190	1,173	38.9
13 Итали	3,136	3,607	471	15
14 Нидерланд	3,733	3,579	(154)	-4.1
15 Канад	3,483	3,529	46	1.3
16 Бусад	42,703	47,603	4,900	11.5
Аялал жуулчлалын салбарын орлого				
Ам.доллар	523,696,452	580,328,820	56,632,368	10.8

7. Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон ТББ-тай хамтран ажиллах ажлын хүрээнд:

- НЦГ-тай байгуулсан 2017-2020 онд хамтран ажиллах Санамж бичгийн дагуу гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, жуулчдад Монголын түүх соёл, нийслэл хотоо сурталчлах зорилгоор Нийслэлийн Цагдаагийн газар, Монголын Оюутны Холбоотой хамтран “Оюутан цагдаа-2019” арга хэмжээг жуулчны улирлын хугацаанд /6,7,8-р сард/ их, дээд сургуулийн 40 оюутныг хамруулан 6 дахь жилдээ зохион байгуулж, 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдөр ажлаа дүгнэлээ. Энэ жилийн

“Оюутан цагдаа-2019” арга хэмжээг зохион байгуулахдаа нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсүүдээс санал авч Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал, Улаанбаатар хотын Төмөр зам /вокзал/-ын орчмын худалдаа, үйлчилгээний төв, гадаадын жуулчид ихээр зорчдог, дамжин өнгөрдөг, хөл хөдөлгөөн ихтэй газруудад эргүүлийн 20 чиглэлд 40 оюутан цагдаа 312 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэв.

Энэхүү арга хэмжээ нь 2014 оноос эхлэн хэрэгжсэн бөгөөд 2014 онд 90, 2015 онд 85, 2016 онд 110, 2017 онд 30, 2018 онд 36 оюутан хамрагдаж, энэ хугацаанд гэмт хэрэгт өртсөн зөрчлийн тоо 2014 онд -17% /35/, 2015 онд -20%/28/, 2016 онд -18%/23/, 2017 онд -33% /16/, 2018 онд -44,6%-иар буюу жилд дундажаар -27%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



- Нийслэлийн Засаг даргын 2015 оны Улаанбаатар хотын авто замын ачааллыг зохицуулах нэмэлт зарим арга хэмжээ авах тухай А/469 дүгээр захирамжийн дагуу Жуулчин тээврийн үйлчилгээний 8-аас дээш хүний суудалтай зөвшөөрөл бүхий автобусанд улсын дугаарын хязгаарлалтгүй замын хөдөлгөөнд оролцуулах зөвшөөрлийг 83 аялал жуулчлалын байгууллагын 800 автомашинд олгов.

Хүчингүй болсон 2018 оны зөвшөөрөл

2019 оны зөвшөөрлийн загвар
Ар тал



Урд тал



- Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд үйл ажиллагаанд тавих хяналт, хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар хамтран “Дэн болон зочид буудлын үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, 9 дүүргийн ЗДТГ, ЦХ, НМХГ-ын 40 гаруй байгууллагын удирдах албан хаагч оролцов. Хэлэлцүүлгээс аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийх, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох, стандарт журам, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр Нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хэмжээнд ажлын хэсэг байгуулж ажиллах, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад хяналтаа сайжруулж ажиллахаар болсон.



- Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байдаг Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт гадаад дотоодын аялагчдын аюулгүй, таатай аялах орчин нөхцөлийг

бүрдүүлэх, цаашид хамтарч ажиллах зорилгоор 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр уулзалт зохион байгуулав. Уулзалтад Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Хашмаргад, Налайх дүүргийн ЗДТГ-ын ХТХУ-ний хэлтсийн дарга Ц.Тунгалаг, Налайх дүүргийн 6 дугаар хорооны засаг дарга Б.Болд болон бусад албан хаагчид оролцов. Уулзалтаар Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газар нь Улаанбаатар хоттой ойр аялагч, амрагчдын тоо жилээс жилд нэмэгдэхийн зэрэгцээ, хог хаягдал ихсэж, ус, хөрс орчны бохирдол нэмэгдэж байгаа мөн зүүн аймгуудаас малчид орноор нүүж ирж суурьших болсон, газар олголт, газрын төлбөр, хураамж, цаашид авах арга хэмжээний талаар ярилцлаа.

- Нийслэлийн Засаг даргын 2015 оны Улаанбаатар хотын авто замын ачааллыг зохицуулах нэмэлт зарим арга хэмжээ авах тухай А/469 дүгээр захирамжийн дагуу Жуулчин тээврийн үйлчилгээний автобусны зориулалтын зогсоол, тэмдэг тэмдэглэгээг Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайн урд хэсэг, Монголын Бурхан шашинтны төв “Гандантэгчэнлин хийд”, Монголын Үндэсний түүхийн музей, “Бурхан Багшийн цэцэрлэгт хүрээлэн”-гийн талбайд түр хугацаагаар байгуулахаар Тээврийн Цагдаагийн алба, Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүсэлт гаргаад шийдвэрлүүлэв.

- Аялал жуулчлалын жолоочдын холбоо ТББ-аас “Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд жолооч миний гүйцэтгэх үүрэг” чуулганд жуулчин тээврийн 67 байгууллагын 600 гаруй жолооч оролцлоо. Чуулганаар жуулчин тээврийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, цаашид хийгдэх ажлууд зэрэг асуудлыг төр хувийн хэвшлийнхэн хамтран хэлэлцсэн юм. Хэлэлцүүлэгт тус газрын дарга Д.Батсүх, ахлах мэргэжилтэн Э.Мөнхзул нар оролцож, жуулчин тээврийн талаар нийслэлд хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээлэл өгч, чуулганд оролцогчдын асуултад хариулж, мэдээлэл өглөө.



Зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн дагуу:

Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллах зорилгоор жуулчин тээврийн үйлчилгээний автобусыг зогсоох, зориулалтын зогсоолыг жуулчны улиралд түр хугацаагаар байгуулах тэмдэг, тэмдэглэгээний загварыг дэлхийн бусад хотуудад хэрэглэгддэг жишгээр НАЗХГ, ТЦА-тай хамтран боловсруулж, тэмдэг хийх зардлын төсвийг Улаанбаатар зам арчлалт компаниар хийлгүүлж, эхний ээлжинд Үндэсний түүхийн музейн урд талбайд өөрийнх нь хөрөнгөөр хийлгэж байршуулав. Гандан, Зайсан цогцолбор, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн, Д.Сүхбаатарын талбай зэрэг нийтийн эзэмшлийн газарт НАЗХГ-ын хөрөнгөөр хийлгэв. Цаашид УИД, галарей Улаанбаатар, Дүнжингарав худалдааны төвүүдэд өөрсдийнх нь хөрөнгөөр хийлгүүлж байршуулах, зохицуулалт хийж ажиллах талаар Зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.

ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АВТОБУСНЫ ЗОГСООЛЫН ТЭМДГИЙН ЗАГВАР



- Нийслэлийн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо хамтран 5 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд “Хөтөч, тайлбарлагчдын ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдад Улаанбаатар хотыг эерэгээр, зөв тайлбарлах, жуулчдын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн анхан шатны мэдлэг, мэдээллийг 80 хөтөч, тайлбарлагчдад олгов.


- Налайх дүүргийн 6 хорооны нутаг дэвсгэрт морь, тэмээн үйлчилгээ эрхэлдэг 40 иргэдтэй уулзалт хийж, уулзалтад Нийслэлийн Аялал жуулчлалын газрын орлогч дарга Ц.Энхтүвшин, Налайх дүүргийн ЗДТГ-ын ХТХҮ-ний хэлтсийн дарга Ц.Тунгалаг, Налайх дүүргийн 6 дугаар хорооны засаг дарга Б.Болд, Налайх дүүргийн цагдаагийн хэсгийн ахлагч н.Батсайхан нар оролцлоо. Энэ үеэр морь, тэмээн үйлчилгээ эрхлэгч иргэдийг бүртгэлжүүлэн, харилцаа хандлага, хууль эрх зүйн сургалтад хамруулав. Цаашид морь тэмээн үйлчилгээ эрхлэгчдийг хууль эрх зүй, харилцаа хандлага, жуулчны аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах сургалтад хамруулах, үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулан бүртгэлжүүлэх, нөхөрлөл хэлбэрээр нэгдсэн зохион байгуулалтад оруулах, үйлчилгээний мэдээлэл, үнэ тарифыг нэгдсэн байдлаар тогтоох, ил тод байршуулах болон саравч, сандал зэрэг тохижилт, хогны асуудлыг дүүрэг хариуцан ажиллах, үйлчилгээ эрхлэгчдэд цагдаагийн хэсэг хяналт тавьж ажиллахаар боллоо.



- Үйлчилгээний ажилтнуудад хууль эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр Оюутан цагдаа, Хөтөч тайлбарлагч, Залуу хөтөч, Морь тэмээн үйлчилгээ эрхэлдэг иргэд, Сайн дурын ажилтнууд, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг дэн буудлын төлөөлөл зэрэг нийт 485 иргэнг сургалтад хамруулав.

Жуулчны аюулгүй байдлыг хангах, хууль эрх зүйн мэдлэг олгосон сургалтын судалгааг хүснэгт, гарфикаар үзүүлэв. /Сүүлийн 4 жилээр/

д/д	Сургалт сэдэв	Он	Хамрагдсан тоо
1	“Оюутан цагдаа” сургалт	2016	90
		2017	82
		2018	35
		2019	40
2	Эрсдлийн менежментийн сургалт	2016	724
3	Монголд амьдарч байгаа гадаад оюутнуудад зориулсан хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт	2017	135
4	Улаанбаатар төмөр замтай хамтарсан хил орчмын аялал жуулчлалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт	2018	256
5	Оюутан цагдаа, Хөтөч тайлбарлагч, Залуу хөтөч, Морь, тэмээн үйлчилгээ эрхэлдэг иргэд, Сайн дурын ажилтнууд, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг дэн буудлын төлөөлөлд хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт	2019	485
	НИЙТ ДҮН		1847



8. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод сургалтад хамруулж, мэргэшлийг дээшлүүлэх ажлын хүрээнд:

Худалдан авах ажиллагааны чиглэлээр АЗ сертификаттай сургалтад В.Батчимэг, М.Болортуяа, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан, биелэлт гаргах сургалтад Д.Ганболд, С.Баяржаргал, “Зөв төр-Шударга ёс” төрийн албан хаагчдын ёс зүйн сургалт Э.Мөнхзул, С.Баяржаргал, Төрийн албан хаагчийн ёс зүй,

харилцаа-төрийн үйлчилгээний стандартын чиглэлээр Г.Азжаргал, Гэрэл зураг, кино, дүрс бичлэг, дуу авианы баримтаар хадгаламжийн нэгж бүрдүүлэх ажлын арга зүй, Төрийн байгууллагын зохион байгуулалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл, Төрийн байгууллагын зохион байгуулалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэх чиглэлээр сургалтад архив, бичиг хэргийн ажилтан Т.Туул, Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албаны тухай хууль, хууль батлагдсан гарсантай холбогдсон УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, бусад дүрэм журам танилцуулах сургалтад Д.Ганболд, С.Баяржрагал, Аялал жуулчлалын бүс нутаг төлөвлөлт /Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагын зөвлөх/ Э.Мөнхзул, Ш.Ундармаа, М.Болортуяа, С.Баяржаргал, Г.Азжаргал, З.Оюуншүр, Б.Алтанзаяа, БНСУ-ын Чезү хотод туршлага судлах семинар Э.Даваамөнх, Д.Болорчимэг, МIСЕ аялал жуулчлалын сургалтад Ч.Энх-Отгон, З.Оюуншүр Г.Азжаргал, НХХЯ-ны харьяа Мэргэжлийн Боловсрол, сургалтын үнэлгээний төвийн “Чадамжийн үнэлгээ, баталгаажуулалт” анхан шат болон Модуль-2 шатны сургалтад /Үнэлгээний ажилтны сертификат/ Э.Мөнхзул, Хөтөч тайлбарлагчийн сургалтад Д.Болорчимэг, Түүх архелогийн сургалтад Н.Алтанзаяа, Б.Ишдорж, "Одон орон, сансарын огторгуй" аяллын менежер, хөтөч тайлбарлагч нарт зориулсан сургалтад Б.Ишдорж, Power point, Ш.Ундармаа, Ч.Энх-Отгон, Оюуншүр, Ишдорж, Даваамөнх, Жаргалан, Photoshop сургалтад М.Болортуяа, Хүний нөөцийн мэргэшүүлэх сургалтад С.Баяржаргал, хэвлэл мэдээллийн тогтвортой байдал сургалтад Г.Азжаргал, “Эрүүл ажлын байр-Эрүүл амьдралын хэв маяг” сэдвээр Б.Ишдорж, Контент маркетинг чиглэлээр Б.Алтанчимэг, Оюуны өмч, Mongolia.travel Аялал жуулчлалын цахим платформын танилцуулга, сургалтад Б.Алтанчимэг, М.Болортуяа, Б.Энхжин, БОАЖЯ-наас зохион байгуулсан Япон улсын экспертийн сургалтад мэргэжилтэн Н.Алтанзаа, Б.Ишдорж, Ш.Ундармаа, Б.Жаргалан, Д.Оюуншүр, НХХЯ-ны харьяа Мэргэжлийн Боловсрол, сургалтын үнэлгээний төвийн “Чадамжийн үнэлгээ, баталгаажуулалт” анхан шатны сургалтад мэргэжилтэн С.Туул, Ч.Энх-Отгон нар нийт 32 удаагийн сургалтад давхардсан тоогоор 58 ажилтанг хамрууллаа. Гадаад улсад зохион байгуулагддаг 7 үзэсгэлэн арга хэмжээнд 15 ажилтан оролцов.

9. Улаанбаатар хоттой хамтын ажиллагаатай хотуудтай аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, нийслэл хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

Улаанбаатар хоттой хамтын ажиллагаатай хотууд, тэдгээрийн аялал жуулчлалын салбарын байгууллагуудтай холбогдон, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хамтарсан үйл ажиллагаанууд зохион байгуулах чиглэлээр ажиллаж байна. Мөн шинээр хамтын ажиллагааг бий болгох Тухайлбал, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос, Улаанцав хотуудтай Аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах санамж бичгүүдийг үйлдээд байна.

10. Аялал жуулчлалын байгууллагуудын дунд аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:

БОАЖЯ-наас санхүүжилтээр Улаанбаатар бүсийн сургалтыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан харилцаа хандлагын сургалт /хил, гааль/-д-579 хүн, үйлчилгээний байгууллагуудын Удирдлага, менежерийн сургалтад 255, Хөдөлмөрийн аюулгүй байдал, АБЭА-ны сургалтад 109, Зочин хүлээн авагчийн сургалтад 111, Өрөөний үйлчлэгчийн сургалтад 190, Зөөгчийн сургалтад 166, Гэрийн үйлчлэгчийн сургалтад 62, Хаалгач, ачаа тээш зөөгчийн сургалтад 38, Хөтөч, тайлбарлагчдын сургалтад 433, Баристагийн сургалтад 290, Бартендерийн сургалтад 210, Үйлчилгээний байгууллагын харилцааны сургалтад 181, Жолоочийн сургалтад-203, Тогоочийн сургалтад 162, жуулчидтай харилцдаг төрийн байгууллагуудын ажилтнуудад

зориулсан харилцаа, хандлагын сургалтад 579, нийт мэргэжил тус бүрээр 2410 ажилтанг хамруулав.

Төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан харилцаа хандлагын сургалт



- Удирдлага, менежерийн сургалт




- ХАБЭА-ны сургалт



- Зочин хүлээн авагчийн сургалт



- Өрөөний үйлчлэгчийн сургалт




- Зөөгчийн сургалт



- Гэрийн үйлчлэгчийн сургалт



- Хаалгач, ачаа тээш зөөгчийн сургалт



- Хөтөч, тайлбарлагчдын сургалт



- Баристагийн сургалт



- Бартендерийн сургалт



- Үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудын харилцааны сургалт



- Жуулчинд үйлчлэх жолоочийн сургалт



- Тогоочийн сургалт



- Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо хамтран 2019 оны 05-р сарын 11, 12-ны өдөр “Хөтөч, тайлбарлагчдын ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь” сургалтыг амжилттай зохион байгууллаа. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулсан тус сургалт нь аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч нарт Улаанбаатар хотыг эерэгээр, зөв тайлбарлах, гадаад, дотоодын жуулчны аюулгүй байдлыг хангах, хууль эрх зүйн анхан шатны мэдлэг, мэдээллийг олгоход чиглэгдэж байлаа. Аялал жуулчлалын компаниудын нийт 80 мэргэжлийн хөтөч, тайлбарлагч сургалтад хамрагдсан бөгөөд Францын Луйврын музейн тайлбарлагч Г.Оюунтунгалаг уригдан оролцож хөтөч, тайлбарлагч нарт олон улсын чиг хандлага гэсэн сэдвээр илтгэл тавьж, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбооны багш нар Улаанбаатар хотын автобустай болон явган аяллын дадлага хичээлийг хийлээ.





- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран гадаад хэлний зохих мэдлэгтэй оюутан, залуучуудыг аялал жуулчлалын салбарт хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 3 дахь жилдээ “Нийслэлийн залуу хөтөч” сургалтыг 2019 оны 06-р сарын 17-20-ны өдрүүдэд Нийслэлийн Иргэний танхимд амжилттай зохион байгууллаа. “Нийслэлийн Залуу хөтөч” сургалтад нийт 313 залуус бүртгүүлж, амжилттай суралцсан 227 залуус 2019 оны 06-р сарын 19-ний өдөр батламжаа гардан авсан. Амжилттай суралцсан залуучуудаас сургалтын агуулгын хүрээнд эссэ болон тестээр шалгалт авч өндөр оноо авсан 90 залуусыг “Сити тур” хотын автобустай аялалд 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хамруулж, Улаанбаатар хотын түүх, соёлын дурсгалт газруудын танилцах дадлага хичээлийг мэргэжлийн хөтөч, тайлбарлагчидтай хамтран зохион байгуулав.

“НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУ ХӨТӨЧ”

ГАДААД, ДОТООДЫН ЖУУЛЧДАД ҮЙЛЧЛЭХ АЯЛЛЫН ХӨТЧИЙН ТАЛААРХ АНХАН ШАТНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ

Гэдаад хэлний зохих мэдлэгтэй оюутан, залуучуудыг **ТӨЛБӨРГҮЙ** сургалтад урьж байна.

СУРГАЛТАД ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

- Та өөрийн биеэр Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт ирж, анкет бөглөн бүртгүүлэх боломжтой. /СБД 8-р хороо, Нийслэлийн Засаг захиргааны 5 дугаар байр Б корпус 206 тоот/
- Цахим хэлбэрээр бүртгүүлэхдээ: Child.gov.mn цахим сайтаас “хөтөч анкет” татан авч бөглөн ubyouthdevelopment@gmail.com хаягаар илгээж болно.

БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА:
2019.06.05-2019.06.14-ны хооронд 08:00-17:00 цаг хүртэл

СУРГАЛТ ХЭЗЭЭ, ХААНА БОЛОХ ВЭ?
Хаана: Нийслэлийн иргэний танхим
Хэзээ: 2019.06.17-19 /13-18 цагийн хооронд/

2019.06.20-ны өдөр шалгалтад тэнцсэн 90 залуу мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн хамт нийслэл Улаанбаатар хотын түүх, соёлтой танилцах нэг өдрийн автобустай аялал хийнэ.

ХОЛБОО БАРИХ:
9712-5557, 9812-5557

Ажлын байранд зуучлагдах боломжоор хангагдана. Сургалтад хамрагдсан залуучуудад БАТЛАМЖ олгоно.



- Монголын Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоотой хамтран хөтөч, тайлбарлагчдыг бэлтгэх сургалтыг 2019 оны 01-04 дүгээр сард үе шаттайгаар зохион байгуулав. Нийт гурван удаагийн сургалтад 92 иргэн хамрагдаж, шаардлага хангасан 46 иргэнд мэргэжлийн хөтөч, тайлбарлагчийн гэрчилгээ гардуулав. Сургалтыг Дэлхийн хөтөч, тайлбарлагчдын холбооны сургалтын хөтөлбөрийн хүрээнд, тус хөтөлбөрийн дагуу бэлтгэгдсэн багш нар удирдан явууллаа. Ингэснээр хөтөч, тайлбарлагчдыг олон улсын стандартын дагуу бэлтгэн гаргасан нь тус сургалтын онцлог байв. Мөн сургалтын хөтөлбөрт хотын аялал, музейн тайлбарыг хэрхэн явуулах багц цагуудыг багтааж, Монголын Үндэсний музей, Улаанбаатар музейг сургалтын бааз болгон зохион байгууллаа.



- “Жуулчин” ХХК-ийн тавьсан саналын дагуу хөтөч, тайлбарлагчдыг чадваржуулах сургалтыг дэмжин ажиллалаа. Тус сургалт 2019 оны 04.01-19-ний өдрүүдэд Мэдээлэл сурталчилгааны төвийн сургалтын танхимд зохион байгуулав. Сургалтад нийт 20 хөтөч, тайлбарлагч хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлж байна.


- Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизтэй байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд олон улсын хэмжээнд зохион байгуулсан “Робокон” тэмцээний үеэр ажиллах сайн дурын ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг 2019 оны 08-р сарын 02-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Сургалтад нийт 70 сайн дурын ажилтан хамрагдаж, “Робокон” олон улсын тэмцээний зохион байгуулалтад оролцон ажиллалаа. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын түүх, соёл, хотын танилцуулга, түүхэн дурсгалт газар, гол үзмэрүүд, орон орны иргэдийн соёлын ялгаа, сайн дурын ажилтнуудын бие авч явах соёл, харилцаа, хандлага, жуулчдад мэдээлэл өгөхдөө англи хэлний зөв тайлбарыг хэрхэн хийх зөвлөмж, мэдээ, мэдээллийг олголоо. Мөн гадаадын иргэд,

жуулчинд аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн анхан шатны тусламжийг хэрхэн үзүүлэх дадлага хичээлийг заасан. Сургалтыг Монголын мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо, Монголын яаралтай түргэн тусламжийн хөгжлийн төвийн багш нар удирдан явуулав.

- “Зочлох үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх нь” сургалтыг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монголын зочид буудлуудын холбоотой хамтран 2019 оны 11-р сарын 15-ны өдөр “Пума империа” зочид буудалд зохион байгуулав. Сургалтад тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг дэн буудлын 28 төлөөлөл оролцож, зочлох үйлчилгээний онцлог, зочинтой харилцах харилцааны арга зүй, зочлох үйлчилгээний салбарын стандартын хэрэгжилт, орчин үеийн технологийн шийдэл, дэн буудлын үйлчилгээнд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн сэдвээр мэдээ, мэдээллийг олголоо.

2019 онд нийт 27 мэргэжлийн байгууллагатай хамтран 27 чиглэлээр аялал жуулчлалын салбарын ажилтан, албан хаагч, иргэн 3546 хүнийг сургалтад хамрууллаа.

Зохион байгуулсан сургалтын судалгааг графикаар үзүүлбэл:



2019 онд нийт сургалтад хамрагдсан иргэдээс хөтөч, тайлбарлагчдын сургалтад хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

д/д	Сургалт сэдэв	Хугацаа	Хамрагдсан тоо
1	Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтад хамрагдсан хөтөч, тайлбарлагчид	2019.05-06	433
2	Хөтөч, тайлбарлагчдын ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт	2019.05.11-12	80
3	Нийслэлийн Залуу хөтөч сургалт	2019.06.17-20	227
4	Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоотой хамтран зохион байгуулсан 3 удаагийн сургалт	2019.01-04-р сар	92
5	“Жуулчин” ХХК-тай хамтран зохион байгуулсан сургалт	2019.04.01-19	20

	Нийт дүн		852
--	----------	--	-----

Мэргэжлийн сургалтад зарцуулсан төсвийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:
/Сүүлийн 5 жилээр/

д/д	Он	Сургалтын тоо/төрөл/	Төсөв	Хамрагдсан хүний тоо	Хамтарч ажилласан байгууллагын тоо
1	2015	16	11.063.360	1127	15
2	2016	8	40.000.000	1685	22
3	2017	5	9.640.000	736	6
4	2018	7	-	553	8
5	2019	27	6.220.000	3546	27
Нийт дүн		90	75.955.048	9274	145

11. Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангаж, УБ хотын талаарх сурталчилгааны материалуудыг тогтмол шинэчлэх арга хэмжээ авч ажиллах талаар:

- Гадаад, дотоодын иргэд, жуулчдад www.touristinfo.ub.gov.mn, www.visitulaanbaatar.mn цахим хуудсаар тус газрын үндсэн үйл ажиллагаа, бодлого чиглэл, хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн мэдээ, мэдээллийг цаг тухайд нь олон нийтэд хүргэн ажиллаж байна.

- “Улаанбаатар хотын албан ёсны хөтөч ном” 5000 ширхэг, Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл 5000 ширхэг, Улаанбаатар хотын болон хот орчмын аялал жуулчлалын газрын зураг 10000 ширхэгийг тус тус хэвлэн, Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд, эвент арга хэмжээнүүдийн үеэр гарсан түр мэдээллийн төвүүдээр тараан ажилласав. Мөн “Ай-Ти-Би Берлин”, “Байкалтур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНХАУ-ын ӨМӨЗО-нд зохион байгуулсан Улаанбаатарын сурталчлах өдөрлөгийн үеэр Ulaanbaatar Your Gateway сэтгүүлийн герман, орос, хятад хэл дээрх 5300 ширхэг сэтгүүлийг тараан ажиллаа.

- 2019 оны 5 дугаар сарын 24-25-ны өдөр Мишээл экспод зохион байгуулсан “Улаанбаатар аялал жуулчлалын үзэсгэлэн”, 2019 оны 9 дүгээр сарын 16-29-ний өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан БОАЖЯ-ны “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож байгууллагын үйл ажиллагааны танилцуулга 1000ш, гарын авлага 100ш, Улаанбаатар хотын газрын зураг 150ш, Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний газрын зураг 200ш, Улаанбаатар хотын сэтгүүл орос, англи, хятад хэл дээр 250ш, цайны зам олон улсын аялал жуулчлалын төслийн танилцуулга 50ш, зочид буудал, дэн буудал, амралтын газрын зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, жуулчин тээврийн зөвшөөрөл авахад бүрдүүлэлт материалын жагсаалт 200, нийт 1950 гарын авлага тарааж, 800 хүнд мэдээлэл өгч ажиллав.

12. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн үзэсгэлэн, арга хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-уудыг хамруулах талаар:

ХБНГУ-ын Берлин хотод 2019 оны 03 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ай-Ти-Би Берлин 2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын 8 тур оператор компани, ОХУ-ын Эрхүү хотод хотод 03 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Байкалтур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын 10 компани, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос, Улаан цав хотуудад 06-р сарын 19-нөөс 27-ны өдрүүдэд “Улаанбаатар хотын соёл, аялал жуулчлалыг сурталчлах өдөрлөг”, “Цайны зам” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгч 11 компани, БНСУ-ын Seongnam хотод 9 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Эрүүл мэндийн аялал жуулчлалын форум, үзэсгэлэнд

EMJJ, Luujin holding, Exodus, Airman, Бирга тур зэрэг 5 компани нийт 34 зэрэг компаниудыг олон улсын үзэсгэлэн, хурал зөвлөгөөн арга хэмжээнд оролцуулав.

13. Жуулчдад зориулсан мэдээлэл сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар:

Гадаад, дотоодын иргэд жуулчдыг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангах, зөвлөгөө өгөх зорилгоор тус газрын дэргэд Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн үндсэн 2 салбар /Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр, Төв шуудан/ тогтмол ажиллаж, жуулчны улиралд нэмж 2 /Сөүлийн гудамж дахь Гэр мэдээлийн төв, Соёл амралтын Зайсан хилл цогцолбор/ нийт 4 төвөөр үйл ажиллагаа явуулж гадаадын 3301, дотоодын 689 утсаар 4993 нийт 8983 хүнд мэдээлэл өгч, 4350 гарын авлага материал тарааж ажиллав.



14. Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, тэдгээрийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах талаар:

Гадаадын иргэдийн санал гомдлыг хүлээн авах, мэдээлэл, зөвлөгөөг түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх зорилгоор Жуулчны лавлах утас 70108687 дугаарыг тогтмол ажилладаг 2 төвөөр, жуулчны улиралд Сөүлийн гудамжинд Гэр мэдээллийн төв, Соёл амралтын Зайсан хилл цогцолбор дахь Жуулчны мэдээллийн төвд 91048687, 91038687 дугаарын утсыг тус тус ажиллуулсан. Жуулчны мэдээллийн төвийн лавлах утсаар дотоод, гадаадын иргэд, жуулчдаас жилд дунджаар 4000-5000 дуудлага ирж, мэдээлэл өгдөг байна.

15. Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх талаар:

Жил бүр мэдээлэл, сурталчилгааны төвүүдийн мэдээллийн нэгдсэн санд нийслэл, орон нутгийн аялал жуулчлал, соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд /тур оператор компаниуд, байршуулах хэрэгслүүд, музей галерей, урлагийн байгууллага, үзвэр үйлчилгээний газар, номын дэлгүүр/-ын болон түүх соёлын дурсгалт газрууд гэх мэт 2000 гаруй байгууллагын мэдээллээр мэдээллийн сан үүсгэж, үзвэр, худалдаа, үйлчилгээний хуваарь, аялал жуулчлалын чиглэлээр болон бусад эвент арга хэмжээний мэдээ, мэдээлэл зэрэг 10,000 гаруй мэдээллийг бэлтгэж, шинэчлэн ажилладаг. Жуулчны мэдээллийн төв /Нийслэлийн захиргааны 4-р байр, Төв шуудан, Сөүлийн гудамж дахь жуулчны гэр мэдээллийн төв, Соёл амралтын Зайсан хилл цогцолбор дахь жуулчны мэдээллийн төв /-үүдээр дотоод, гадаадын иргэд, жуулчдад Улаанбаатар хот болон хотын аялал жуулчлал, соёл урлагийн байгууллагууд, музей үзвэрийн газруудын талаар тогтмол мэдээлэл өгөн ажиллаж байна. 2016-2019 он хүртэл дээрх мэдээллийн төвүүдээр нийт гадаад, дотоодын 8.000 гаруй иргэд жуулчдад мэдээлэл өгч ажилласан байна.

16. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх талаар:

Эрхэлсэн ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гадаад харилцааны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүд, Захирагчийн ажлын алба, нийслэлийн 9 дүүрэг, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургуулиуд, төрийн бус байгууллагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээ мэдээллийг цаг тухайд түргэн шуурхай өгч ажиллаж байна.

17. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах талаар:

Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Улаанбаатарын Аялал жуулчлалын холбоо ТББ, Монголын Аялал жуулчлалын холбоо ТББ, Монголын Зочид буудлуудын холбоо ТББ, ИНЕГ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах Санамж бичиг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн “Улаанбаатарын өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Талын салхи”, “Улаанбаатар үзэсгэлэн”, “Аялал жуулчлал ба хөдөлмөр эрхлэлт” зэрэг арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүллээ.

БНСУ-ын Чэжү Олле нийгэмлэгтэй байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийн дагуу Монгол Олле төсөл болон явган аяллын маршрутын мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор 2019 оны 5 дугаар сараас Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Сөүлийн гудамжинд байрлах Цагдаагийн газрын “Иргэдэд үйлчлэх төв”-ийн 1 давхарт “Монгол Олле төслийн мэдээллийн төв”-ийг ажиллуулсан.

18. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийн хүрээнд:


А. Зохион байгуулалтын чиглэлээр:

- Авилгын эсрэг хууль тогтоомж, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор tourism.ub.gov.mn цахим хуудас, шилэн данс цэсийн мэдээллийг цаг тухай бүр шинэчлэн ажиллав.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тус байгууллагын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлын хурлаас гаргасан зөвлөмжийн дагуу 15 заалттай ажлын төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллав.
- Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг газрын хурлаар нийт албан хаагчдад тогтмол танилцуулж, үүрэг даалгаврын


- хэрэгжилтэд хүний нөөц, аялал жуулчлалын байгууллага хариуцсан мэргэжилтэн хяналт тавин ажиллав. Тус газартай холбоотой үүрэг даалгаварын биелэлтийг Ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллав. Газрын хурлыг сард 1 удаа зохион байгуулж нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, байгууллагын төлөвлөгөөт ажлын хэрэгжилт, түүний үр дүн цаашид хийх ажлууд, аялал жуулчлалтай холбоотой сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг танилцуулж, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар түүний хэрэгжилтийг байгууллагын дотоод сүлжээнд тогтмол байрлуулан ажиллав.
- МУ-ын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлиг, Ойн тухай хуулийн дагуу хаврын “Бүх нийтийн мод тарих өдөр”-өөр тус байгууллагын албан хаагчдаас нийт 85.000 төгрөгийг Ногоон байгууламжийн санд хандивлав.
 - 2019 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Бямба гаригийн 11 цагт “Их цэвэрлэгээний 90 минут” бүх нийтийн арга хэмжээнд тус газрын 18 албан хаагчид Их тэнгэрийн амны харалдаа хойд талаас зүүн тийш 800м Туул голыг урд эрэг дагуу талбайг цэвэрлэн 24 хаягдал дугуй, 20 хогийн уут, 20 шуудай хог ачуулж, мэдээг Нийслэлийн шуурхай удирдлагын 310005 утсанд өгөв.
 - Нийслэлийн Эрүүл мэндийн газраас гаргасан Эрсдэлгүй-Эрүүл орчин, Хачигт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлье, Томуу, томуу төст өвчнөөс сэргийлье, Хүүхдийн хамгаалалтын суудал, Алхалтын ач холбогдол Сүрьеэ өвчнөөс хамтдаа урьдчилан сэргийлье, Иргэн танд зориулав /гарын авлага/, Бэлгийн замаар дамжих халдварт өвчин гэсэн 8 төрлийн хэвлэмэл сурталчилгааны материалыг Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 150 зочид буудал, дэн буудалд хүргүүлж, зөвлөгөө өгч ажиллалаа.
 - Ерөнхий боловсролын сургуулийн ойролцоо үйл ажиллагаа явуулж байсан Сүхбаатар дүүргийн Фокус дэн буудал, Сонгинохайрхан дүүргийн 15-р хорооны нутаг дэвсгэр дээрх Вегвайзер, болон Сонгинохайрхан дүүргийн 13-р хорооны Тав Тух дэн буудлуудад үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн ажиллах зөвлөгөө өгч, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоогүй болно.
 - Нийтийн эзэмшлийн зам талбай хаасан Сонгинохайрхан дүүргийн 11-р хорооны “Ногоон туяа” дэн буудалд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоогүй, мөн тус нутаг дэвсгэрт байрлах “Шивнээ дэн” буудлын үүдний хэсэг нийтийн эзэмшлийн талбай руу орсон байсныг буулгуулж, зам талбайг чөлөөтэй болгуулав. Сонгинохайрхан дүүргийн 29-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Драгон” дэн буудал, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Бэрс” дэн буудал, “Агь” дэн буудлын үүдний орох хэсэг, шатыг халтиргаа гулгаанаас хамгаалах, гадна талбайн цасыг цэвэрлэж үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах талаар зөвлөгөө өгөв.
 - Гэмт хэрэг гарах нөхцөл бүрдүүлж, бусдыг биеэ үнэлэхэд орон байраар хангасан, бусдыг мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн БЗД-ийн 6-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Бумбашүр ХХК-ийн Лайк зочид буудал, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага хангаагүй БГД-ийн 16-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Ланд тек ХХК-ийн Секрет дэн буудал, 3-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Ай эм ай трейвел ХХК-ийн Анарс дэн буудлын зөвшөөрлийг хүчингүй болгов.
 - 2019 оны 5 дугаар сарын 24-25-ны өдөр Мишээл экспод зохион байгуулсан “Улаанбаатар аялал жуулчлалын үзэсгэлэн”, 2019 оны 9 дүгээр сарын 16-29-ний өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан БОАЖЯ-ны “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож байгууллагын үйл ажиллагааны танилцуулга 1000ш, гарын авлага 100ш, Улаанбаатар хотын газрын зураг 150ш, Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний газрын зураг 200ш, Улаанбаатар хотын сэтгүүл орос, англи, хятад хэл дээр 250ш, цайны зам олон улсын аялал жуулчлалын төслийн танилцуулга 50ш, зочид буудал, дэн буудал, амралтын газрын зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, жуулчин тээврийн зөвшөөрөл авахад бүрдүүлэлт материалын жагсаалт 200, нийт 1950 гарын авлага тарааж, 800 хүнд мэдээлэл өгч ажиллав.



- Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Нисэх буудлуудын удирдах газартай хамтран ажиллах санамж бичгийг 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан. Санамж бичгийн хүрээнд Улаанбаатар хотод ирж буй дотоод, гадаадын иргэд, жуулчдад аялал жуулчлалын маркетинг сурталчилгааг хийх, аюулгүй зорчих нөхцлөөр хангах зорилгоор Жуулчны мэдээллийн төв ажиллуулах, такси болон автобусны үйлчилгээг нэвтрүүлэх, зорчигч, жуулчидтай харилцдаг албан хаагчдыг харилцаа хандлагын сургалтад хамруулах, чиглэлээр хамтран ажиллахаар болов.



- Монгол Улсад Аялал жуулчлалын салбар үүсч хөгжсөний 65 жилийн ойг тохиолдуулан 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт салбарын төгөл байгуулах ажилд нийт ажилтнууд оролцов.





- Нийслэл Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн хөгжилд аялал жуулчлалын салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлж, олон улсад Улаанбаатар хотыг таниулан сурталчлах ажилд амжилт гаргасан, олон улсын стандартад хүрсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагад олгох “Хотын Аялал жуулчлалын элч” цом, батламж бүхий шагналыг бий болгох, шагнах ажлыг зохион байгуулах төсөл боловсруулж, цом өргөмжлөлийн загвар гаргаж батлуулав.

Б. Цаг үеийн ажлын шаардлагаар дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаар:

- Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай” 2019 оны А/417 дугаар захирамжийг нийт албан хаагчдад танилцуулан 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлэн ажиллав.
- Цаг агаарын хэт хуурайшилтын улмаас ойн хээрийн түймрийн эрсдэл нэмэгдсэнтэй холбогдуулан 2019 оны 4 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Нийслэлийн 9 дүүргийн 183 амралтын газарт Нийслэлийн Засаг дарын А/329 дугаар захирамжийг танилцуулж, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх Сэрэмжлүүлэг, Аялал жуулчлалын тухай хууль болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын дагуу холбогдох зөвшөөрлийг авч ажиллах тухай тус газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 01/161 тоот албан бичгийг хүргүүлж ажиллав. Мөн Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран Гал түймрээс урьдчилан сэргийлэх 3 төрлийн тараах материалыг нийт 150 зочид буудал, дэн буудлуудад хүргүүлэв.
- Нийслэлийн Засаг даргын “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцуулах тухай” 2019 оны А/243 дугаар захирамжийг нийт албан хаагчдад танилцуулж, өөрсдийн харьяа дүүрэг, хорооны болзошгүй гамшгийн үед түр цуглах талбайд очих сургалтад нийт 17 албан хаагч хамрагдсан. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд тус газрын нийт 17 албан хаагч хамрагдсан тухай мэдээг 01/163 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэв.
- Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны №01 дүгээр тогтоолын дагуу Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоходоо гэрээ байгуулан, гэрээнд заалт тусгаж, зөвлөмж хүргүүлж хяналт тавьж ажилласны дүнд Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд хамрагдаж, өвөл үйл ажиллагаа явуулдаг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 35 амралт, 2 зочид буудал, 15 дэн буудал нийт 52 аж ахуйн нэгж байгууллагаас 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар зуух ашиглаж байгууллага 24, цахилгаан халаалтад шилжсэн 28 байгууллага байна. Агаарын

чанарыг сайжруулах бүсэд хамрагдаж байгаа аж ахуй нэгж байгууллагын 85%-ийг цахилгаанд шилжүүлэв.

- Нийслэлийн Эрүүл мэндийн газраас гаргасан Эрсдэлгүй-Эрүүл орчин, Хачигт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлье, Томуу, томуу төст өвчнөөс сэргийлье, Хүүхдийн хамгаалалтын суудал, Алхалтын ач холбогдол Сүрьеэ өвчнөөс хамтдаа урьдчилан сэргийлье, Иргэн танд зориулав /гарын авлага/, Бэлгийн замаар дамжих халдварт өвчин гэсэн 8 төрлийн хэвлэмэл сурталчилгааны материалыг Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 150 зочид буудал, дэн буудалд хүргүүлэв.
- Нийтийн эзэмшлийн зам талбай хаасан Сонгинохайрхан дүүргийн 11-р хорооны Ногоон туяа дэн буудалд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоогүй, мөн тус нутаг дэвсгэрт байрлах Шивнээ дэн буудлын үүдний хэсэг нийтийн эзэмшлийн талбай руу орсонг буулгуулж, зам талбайг чөлөөтэй болгуулав.
- Ерөнхий боловсролын сургуулийн ойролцоо үйл ажиллагаа явуулж байсан Сүхбаатар дүүргийн Фокус дэн буудал, Сонгинохайрхан дүүргийн 15-р хорооны нутаг дэвсгэр дээрх Вегвайзер, болон Сонгинохайрхан дүүргийн 13-р хорооны Тав Тух дэн буудлуудад үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн ажиллах чиглэлээр зөвлөгөө өгч, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоогүй болно.
- НЗД-ын 2019 оны 04 дугаар Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай албан даалгаврын дагуу Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа дэн буудлуудын удирдах ажилтнуудад “Үйлчилгээний соёлыг хөгжүүлэх”, “Үйлчилгээний менежментийн тогтвортой загвар бүтээхүй”, “Байгууллагыг соёлоор удирдах нь”, “Хүний нөөцийг тогтоон барих менежмент”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ойлголт, дотоод хяналт, шалгалтыг хийх тухай” “Удирдлагын арга барил ба харилцааны онцлог” “Зочид буудлын үйлчилгээний ажилчдын ажлын байрны тодорхойлолт, үндсэн чиг үүрэг” зэрэг сэдвүүдээр нийт 16 цагийн хөтөлбөрөөр 2019 оны 6 дугаар сарын 18,19-ны өдрүүдэд Бишрэлт зочид буудалд сургалт зохион байгууллаа. Сургалтад Улаанбаатар хотын 9 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 115 аж ахуйн нэгжийн 183 захирал, менежер, удирдах албан тушаалтнуудыг хамруулав.
- Нийслэлийн онцгой байдлын газартай хамтран Гал түймрээс урьдчилан сэргийлэх 3 төрлийн тараах материалыг нийт 150 зочид буудал, дэн буудлуудад хүргүүлэв.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Монгол Улсын Засгийн газрын гишүүдтэй уулзах уулзалтын үеэр хэлэлцэгдэх Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудын талаар танилцуулгыг бэлтгэн 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр НЗД-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэв.

УЛААНБААТАР ХОТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД



1. Улаанбаатар хотоор дамжин өнгөрөх олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, цахим виз олгох асуудлыг шийдвэрлэх


- 2018 оны Монгол Улсын Засгийн газрын 145 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөнгөлбөрт 2020 он гэхэд Монгол улс 1 сая жуулчин хүлээн авна гэсэн зорилт тавьсан. Тус зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд одоо байгаа олон улсын нислэгийн дамтажийг 30 хувиар нэмэгдүүлж, өвлийн улирлын нислэгийн дамтажийг 40-40-д хүргэх, зуны нислэгийн дамтажийг 60,60-д хүргэж нь зүйтэй юм.
- Цахим виз олгох асуудлыг шийдвэрлэх



- “UB number” лавлах утасны судалгааг хийж нийслэлийн Засаг даргын зөвлөх Инноваци технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч М.Халиунбат-д 5 дугаар сарын 09-ний өдөр танилцуулав.



- Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг нийслэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө-“Хүчирхийлэлгүй хот” /Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх/ нийслэлийн хөтөлбөрийг 2019-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, Монгол Улсын урт хугацааны бодлого /2020-2045/ болон уг бодлогыг 2020-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний төсөл, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө болон Нийслэлийн 380 жилийн он хүрээнд хийх ажлын төлөвлөгөөнд саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажиллав.
- Нийслэлд Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлын хүрээнд аялал жуулчлалын менежментийг хэрэгжүүлж буй олон улсын туршлага, манай улсад байгуулахаар төлөвлөж буй эдийн засгийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт цаашид үйл ажиллагаа өргөжүүлэх боломжийн талаар нэмэлт мэдээллийг судлан боловсруулж 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 02/221 тоот албан бичгээр “Нийслэлийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлаар холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т хүргүүлж ажиллав.




- Халх голын 80 жилийн ойн хүрээнд мэдээлэл бэлтгэн цахим хуудсаар сурталчилж ажиллав.



Халх голын 80 жилийн ойн арга хэмжээний сурталчилгааны зурагт хуудас хийв.


- Нийслэл хот үүсч хөгжсөний 380 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 380км аяллын маршрут гарган хотын аялал зохион байгуулав.



- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн 17,18 дугаар хороодод байрлах 4122 өрхөд “Таван толгой” ХХК-ний сайжруулсан түлшний тээвэрлэлт, нөөцлөлт, борлуулалтын 8 цэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.

В. Шинээр санаачилсан ажил:

- Нийслэл Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн хөгжилд аялал жуулчлалын салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлж, олон улсад Улаанбаатар хотыг таниулан сурталчлах ажилд амжилт гаргасан, олон улсын стандартад хүрсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагад олгох “Хотын Аялал жуулчлалын элч” цом, батламж бүхий шагналыг бий болгох, шагнах ажлыг зохион байгуулах төсөл боловсруулж, цом өргөмжлөлийн загвар гаргаж батлуулав.



- “Номын соёлт ертөнц” номын өдөрлөг 2019 оны 05 дугаар сарын 23,24,25-ны өдрүүдэд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдав. Өдөрлөгийн үеэр Сити турын аяллыг зохион байгуулж нийслэлийн Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 3,4,5 дугаар ангийн нийт 200 сурагч, 114 дүгээр сургуулийн 3 дугаар ангийн 48 сурагч, Баянзүрх дүүргийн 48 дугаар сургуулийн 2 дугаар ангийн 48 сурагч, зорилтод бүлгийн 65 дугаар сургууль, 85 дугаар сургуулиудын 130 сурагчдыг хамруулж номын өдөрлөгтэй танилцуулав.



Б/. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ

Худалдан авах ажиллагааны чиглэлээр АЗ сертификаттай сургалтад В.Батчимэг, М.Болортуяа, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан, биелэлт гаргах сургалтад Д.Ганболд, С.Баяржаргал, “Зөв төр-Шударга ёс” төрийн албан хаагчдын ёс зүйн сургалт Э.Мөнхзул, С.Баяржаргал, Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа-төрийн үйлчилгээний стандартын чиглэлээр Г.Азжаргал, Гэрэл зураг, кино, дүрс бичлэг, дуу авианы баримтаар хадгаламжийн нэгж бүрдүүлэх ажлын арга зүй, Төрийн байгууллагын зохион байгуулалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл, Төрийн байгууллагын зохион байгуулалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэх чиглэлээр сургалтад архив, бичиг хэргийн ажилтан Т.Туул, Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албаны тухай хууль, хууль батлагдсан гарсантай холбогдсон УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, бусад дүрэм журам танилцуулах сургалтад Д.Ганболд, С.Баяржаргал, Аялал жуулчлалын бүс нутаг төлөвлөлт /Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагын зөвлөх/ Э.Мөнхзул, Ш.Ундармаа, М.Болортуяа, С.Баяржаргал, Г.Азжаргал, З.Оюуншүр, Б.Алтанзаяа, БНСУ-ын Чөжү хотод туршлага судлах семинар Э.Даваамөнх, Д.Болорчимэг, МIСЕ аялал жуулчлалын сургалтад Ч.Энх-Отгон, З.Оюуншүр Г.Азжаргал, НХХЯ-ны харьяа Мэргэжлийн Боловсрол, сургалтын үнэлгээний төвийн “Чадамжийн үнэлгээ, баталгаажуулалт” Модуль-2 шатны сургалтад /Үнэлгээний ажилтны сертификат/ Э.Мөнхзул, Хөтөч тайлбарлагчийн сургалтад Д.Болорчимэг, Түүх археологийн сургалтад

Н.Алтанзаяа, Б.Ишдорж, "Одон орон, сансарын огторгуй" аяллын менежер, хөтөч тайлбарлагч нарт зориулсан сургалтад Б.Ишдорж, Power point, Ш.Ундармаа, Ч.Энх-Отгон, Оюуншүр, Ишдорж, Даваамөнх, Жаргалан, Photoshop сургалтад М.Болортуяа, Хүний нөөцийн мэргэшүүлэх сургалтад С.Бяаржаргал, хэвлэл мэдээллийн тогтвортой байдал сургалтад Г.Азжаргал, "Эрүүл ажлын байр-Эрүүл амьдралын хэв маяг" сэдвээр Б.Ишдорж, Контент маркетинг чиглэлээр Б.Алтанчимэг, Оюуны өмч, Mongolia.travel Аялал жуулчлалын цахим платформын танилцуулга, сургалтад Б.Алтанчимэг, М.Болортуяа, Б.Энхжин, НХХЯ-ны харьяа Мэргэжлийн Боловсрол, сургалтын үнэлгээний төвийн "Чадамжийн үнэлгээ, баталгаажуулалт" анхан шатны сургалтад мэргэжилтэн С.Туул, Ч.Энх-Отгон, БОАЖЯ-наас зохион байгуулсан Япон улсын экспертийн сургалтад мэргэжилтэн Б.Жаргалан, Ш.Ундармаа, Б.Үржинханд, Н.Алтанзаяа нар нийт 26 удаагийн сургалтад давхардсан тоогоор 46 хүн хамрагдлаа.

В. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /КРИ-ЭЭР ҮНЭЛСЭН МЭДЭЭЛЭЛ


а/. Жуулчдад зориулан зохион байгуулж буй эвент арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулж дотоод гадаадын иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлсэн байдал:

2019 онд гадаад, дотоодын иргэд жуулчдад зориулж 9 эвент арга хэмжээ зохион байгуулж 52.500 гадаад дотоодын иргэд, жуулчид хамрагдлаа. Энэ нь өмнөх онтой харьцуулахад эвент арга хэмжээний тоо хэвээрээ, оролцогчдын тоо -42%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь олныг хамарсан арга хэмжээ Даншиг наадам-Хүрээ цам, Гэрэлт гудамжны нээлтийн арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.

Зохион байгуулсан эвент арга хэмжээний харьцуулалт /2017-2019он/







б/. Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах ажлыг оновчтой зохион байгуулж, олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход уг үзэсгэлэнг үзэж сонирхсон хүмүүсийн тооны нэмэгдсэн байдал:

Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах ажлыг зохион байгуулж, олон улсын аялал жуулчлалын 2 үзэсгэлэнд оролцож, давхардсан тоогоор 185 орны 10100 байгууллага оролцож, 180.000 хүн үзэж сонирхсон нь өмнөх онтой харьцуулахад оролцсон үзэсгэлэнгийн тоог 2-оор буурч, оролцсон байгууллагын тоо 3406-аар, оролцсон орны тоо 225-аар, үзэж сонирхсон хүмүүсийн тоо 261,716-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Нийслэлийн удирдлагуудын зүгээс 2018 онд оролцож байсан “Жата” болон “Эмитт” зэрэг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцох шаардлагагүй гэж үзсэн болно.

в/. Улаанбаатар хотод ирсэн жуулчдын зорин очих газрыг шинээр бий болгож аялал жуулчлалын эргэлтэд оруулсан байдал:

Улаанбаатар хотод ирсэн жуулчдын зорин очих газрыг шинээр бий болгож аялал жуулчлалын эргэлтэд оруулахаар тохижилтын 2 ажил төлөвлөж, төсөл боловсруулсан боловч санхүүжилтгүй тул тохижилтын ажлыг хийх боломжгүй болсон.

Г. ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай барагдуулах, санал хүсэлт ирснээс хойш 7 хоногт багтаан шийдвэрлэх талаар заалтыг нийт ажилтнуудын үр дүнгийн гэрээнд тусгаж, байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг байгууллагын хурлаар нийт ажилтнуудад хэлэлцүүлж, 2019 оны байдлаар Засгийн газрын 11-11 төв, нийслэлийн 1800-1200 тусгай дугаарын утас, НЗДТГ-ын Үйлчилгээний Нэгдсэн төвөөр

дамжин тус газарт нийт 23 өргөдөл гомдол, санал хүсэлт ирснээс гомдол 6, байгууллагын хүний нөөцтэй холбоотой хүсэлт 14, хамтран ажиллах санал 3 байна. Хугацаанд нь шийдвэрлэсэн 22, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1 байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг тухай бүр байгууллагын хурлаар танилцуулж, НЗДТГ-ын Үйлчилгээний Нэгдсэн төвд улирал бүр тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллав. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 95.6%-тай байна.

Үзүүлэлт	2018 он		2019 он	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Ирсэн өргөдлийн тоо	30	100	23	95.6%

Д/. БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ

Тус газраас тохижилтын 2 ажил төлөвлөж, төсөл боловсруулсан боловч санхүүжилтгүй тул тохижилтын ажлыг хийх боломжгүй болсон.

Е/. НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САНД ОРУУЛСАН ТАЙЛАН МЭДЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны Журам батлах тухай 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны Журам батлах тухай А/335 дугаар захирамжийн дагуу байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэлийн хамт албан тоотоор НЗДТГ-ын ХШҮХ-т, тайлан мэдээг monitoring.ub.gov.mn сайтад байршуулж ажиллав.

Байгууллагын үйл ажиллагаанд 2019 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөнд нийт таван зорилт, 23 ажлыг төлөвлөж, газрын даргаар батлуулан ажиллаж байна. 2019 оны 11-р сарын 20-ны өдрийн байдлаар бодлогын зорилт, тогтоол шийдвэр, удирдлагаас гаргасан шийдвэр, архив, байгууллагын ил тод байдал, өргөдөл гомдол, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр нийт 16 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Нийслэлийн аялал жуулчлалын газрын дүрэм, үйл ажиллагааны стратеги, эрхэм зорилго, зорилт, бүтцийг цахим хуудсанд шинэчлэн байршуулсан.	100
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал,	Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, албан хаагчдын	100

	ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	харилцах утас цахим хаяг, байгууллагын мөрдөгдөж байгаа дүрэм журмыг цахим хаяг, мэдээллийг самбарт тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна.	
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байрлуулан тухай бүр шинэчлэх	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 120 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз гэр буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, жуулчин тээврийг дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, бүдүүвч зургийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.	100
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм болон Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр холбогдох дүрэм журмыг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулсан.	100
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг байхгүй болно.	-
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх зорилготой www.eservice.ulaanbaatar.mn цахим хаягт тус газраас үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар мэдээллийг байршуулж сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан.	100
7	Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа ажил байхгүй болно.	-

8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудаснаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын зөвшөөрөл олгосон тухай газрын даргын нийт 30 тушаалыг тухай бүр байршуулав.	100
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно.	-
Хэсгийн дундаж хувь:			100
Хоёр: Хүний нөөцийн ил тод байдал			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Сул орон тоо байхгүй болно.	100
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний Ёс зүйн дүрэм” болон уг дүрмийн 6.2-т заасны дагуу нийт албан хаагчдын саналыг үндэслэн байгууллагын Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулсан тухай шийдвэрийн цахим хуудаст байрлуулав.	100
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж байтлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг байгууллагын цахим хуудсанд байрлуулсан.	100
4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хянах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг тухай бүр шинэчлэн байршуулсан.	100

5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлгээг цахим хуудасанд байрлуулж байна.	100
Хэсгийн дундаж хувь			100
Хэрэгжилтийн дундаж хувь			100

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

А/. Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр:

Нийслэл хотын зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, зочлох үйлчилгээний салбарын эрхлэгч, менежер, ажилтнууд, жуулчидтай шууд харилцдаг төрийн байгууллагын ажилтнуудад зориулж үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдал, харилцааны соёл, хөтөч-тайлбарлагчийн зэрэг сургалтуудыг зохион байгуулах болон тус газраас жуулчдад зориулсан аялал жуулчлал, спорт, соёл урлагийн арга хэмжээг аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын төлөөлөл бүхий хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх үүднээс 7 төр болон төрийн бус гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, 112 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хэрэгжилтийг ажиллав.

Б/. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажлын талаарх:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгжид үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон ажиллаж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар тус газарт дүүрэг, цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 7 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын тушаалаар хүчингүй болгов.

В/. Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт:

ЦААШИД:

- Аялал жуулчлалын тухай хууль болон дагалдах Мэргэжлийн хяналтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх


- Статистикийн тоо баримтад үндэслэн Улаанбаатар хотын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах

- Дүрмээр хүлээсэн үүргийг хангаж ажиллахад орон тоо, баталсан төсөв хүрэлцэхгүй байгаа

- Гэрээгээр ажиллаж байгаа албан хаагчдыг үндсэн бүтцэд оруулах шаардлагатай

- Салбарын онцлогоос хамааран /жуулчин жилийн өмнөх аялах шийдвэрээ гаргадаг/ зохион байгуулах эвент, оролцох үзэсгэлэнгийн хуваарийг жилийн өмнө НЗДТГ-аас шийдвэрийг тодорхой гаргаж байх
- Тогтмол зохион байгуулдаг арга хэмжээ, үзэсгэлэнгийн төсвийг байгууллагын төсөвт тусгуулах шаардлагатай.

ТАНИЛЦСАН:
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЗУЛ